



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 49

Хажуу шинэ ус

Хүүхдэд хамаатай орчинд үзлэг
шалгалт хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2022 оны А/196 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Өлзийтогтох /Тамгын газрын дарга/
Нарийн бичгийн дарга:	Э.Золжаргал /Сургуулийн нийгмийн ажилтан/
Гишүүд:	Б.Мөнхтөгөлдөр /Нэг дүгээр багийн Засаг дарга/
	Г.Батчулуун /Хоёр дугаар багийн Засаг дарга/
	Б.Наранбаатар /Гурав дугаар багийн Засаг дарга/
	Л.Батбаатар /Дөрөв дүгээр багийн Засаг дарга/
	Э.Ванчиндорж /Хэсгийн төлөөлөгч/

2. Барилга байгууламжийн замын ажлууд эхэлж байгаатай холбогдуулан хүүхдийн аюулгүй байдал, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, сургалтын анги танхим, хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд зорчих зам талбай, хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хийсэн ажлын тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 18-ны дотор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Эрдэнэсүвдад ERP системээр хүргүүлэн танилцуулахыг ажлын хэсэг /Э.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН